МЭДЭЭ · 2022 оны 11-р сарын 11

“ЭЕРГЭЭР НӨЛӨӨЛЬЕ-2” АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЭХЭЛЛЭЭ



Сүхбаатар дүүргийн прокурорын газраас тус дүүргийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн Ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, дүүрэг дэх Цагдаагийн газар болон бусад төрийн байгууллагуудтай хамтран “Эергээр нөлөөлье-2” аяныг зохион байгуулж эхэллээ.

Сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилго бүхий тус нөлөөллийн арга хэмжээг энэ оны 2 дугаар улиралд мөн зохион байгуулж байсан бөгөөд энэ удаагийн аянд дүүргийн нутаг дэвсгэр дэх ахлах бүлэгтэй төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 14 сургууль хамрагдахаар болжээ.

“Эергээр нөлөөлье-2” аяны хүрээнд сургууль бүрт 7 хоногийн хугацаатай “Хорт зуршил-Зорилго биш” сэдэвт сургалтыг явуулж, сурагчдын дунд эссэ бичлэгийн уралдаан зарлах зэрэг ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2013